



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 1/90

Улаанбаатар хот

Жишиг норм, аргачлал шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.19 Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх “Гал түймэр унтраах, аврах, тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжийн шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг нэгдүгээр, “Гал түймэр унтраах болон аврах зориулалтын автомашин, техникийн өдөр тутмын бэлтгэл, бэлэн байдлыг хангах шатахууны зарцуулалтыг тооцох аргачлалыг”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан нормын дагуу шатахууны төсвийг олгохыг Ар тал, санхүү, хөрөнгө оруулалтын газар (хурандаа Я.Гантөмөр)-т зөвшөөрсүгэй.


3. Хавсралтаар батлагдсан норм, аргачлалыг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (хурандаа Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/04 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

АРИУНБУЯН



25	Зил-131 ОВ-95	Машины бүхээг халаагч	53 А-80	2 А-80	10,8 А-80
26	Газ-66 ОВ-65	Машины бүхээг халаагч	38 А-80	1,2 А-80	7,8 А-80
27	МП-800 мотопомп	Усны хөөрөг	-	5 АИ-92	-
28	Мотор УД-2	Цахилгаан үүсгэгч	-	2 АИ-92	-
29	Мотор "Ямаха"	Цахилгаан үүсгэгч	-	1 АИ-92	-
30	Мотояама 2800	Цахилгаан үүсгэгч	-	1,6 АИ-92	-
31	Мотор "Хонда"	Цахилгаан үүсгэгч	-	1 АИ-92	-
32	Үлээгч аппарат	Түймэр унтраах	-	1 АИ-92	-
33	Мотор "Ямаха"	Завины мотор	-	2 АИ-92	-
34	АРС-14У ЗИЛ131	Хими цэвэрлэгээ	53 А-80	19,2 А-80	10,8 А-80
35	ДДА-3Б ЗИЛ131	Ариутгал, уурын тогоо	53 А-80	23,5 А-80	10,8 А-80
36	МАН, Польш	Удирдлагын автомашин	40 ДТ	-	10 ДТ
37	Газель, ОХУ	Аврах ажиллагааны	25 АИ-92	-	2,5 АИ-92
38	Мотоцикл (мустанг)	Тусгай	6 АИ-92	-	0,6 АИ-92
39	Камаз АСА-20	Аврах ажиллагааны	45л ДТ	19 ДТ	9 ДТ
40	Ковш IN-935	Тусгай	16 ДТ	-	1,6 ДТ
41	Квадратцикл ATV SS	Аврах ажиллагааны	8 АИ-92	-	0,8 АИ-92
42	АСА РХА /МАЗ-6317/ Беларусь	Цацраг-химийн аврах ажиллагааны автомашин	45 ДТ	-	13,5 ДТ
43	АСА /МАЗ-6317/ Беларусь	Аврах ажиллагааны автомашин	45 ДТ	-	13,5 ДТ
44	МГП /МАЗ-6317/ Беларусь	Хөдөлгөөнт эмнэлэгийн автомашин	52 ДТ	-	15,6 ДТ
45	ГАЗ 330811-21 /Вифер/	Аврах ажиллагааны	25 ДТ	-	8 ДТ
46	Волксваген Крафтер	Аврах ажиллагааны	18 ДТ	12 ДТ	5 ДТ
47	/МАЗ-231060/ Беларусь	Автобус /31 хүний суудалтай/	40 ДТ	-	15 ДТ
48	/МАЗ-257030/ Беларусь	Автобус /51 хүний суудалтай/	45 ДТ	-	15 ДТ
49	ВА /МАЗ-6317/ Беларусь	Ээлжийн бүрэлдэхүүн тээврийн автомашин	52 ДТ	-	15 ДТ

Б. Гал түймэр унтраах зориулалтын автомашин, тоног төхөөрөмж

д/д	Автомашинны загвар, үйлдвэрлэсэн улс	Төрөл, зориулалт, онцлог	100 км-ийн гүйлтэд зарцуулах шатахуун, литр /төрөл/	Гал түймэр унтраах, аврах дадлага сургууль хийх болон гал түймэр унтраах, аврах ажиллагаанд оролцох үед тусгай тоног төхөөрөмж ажиллуулахад /1 цагт, литр/	Бэлэн байдал хангах, зүгшрүүлэлт хийх асаалт /1 цагт, литр/
1	Мицубиши FK617F /4x2/ мост, Япон	Усан хөөрөгтэй /4тн/	37 ДТ	30 ДТ	8 ДТ
2	ИСУЗУ FTS 33F /4x4/ мост, Япон	Усан хөөрөгтэй /4тн/	40 ДТ	30 ДТ	9 ДТ
3	Мицубиши FY515M, Япон	Усан хөөрөгтэй /10тн/	53 ДТ	54 ДТ	12 ДТ
4	Мицубиши FP517, Япон	Ус тээвэрлэгч /8тн/ мотопомптой	45 ДТ	2,4 АИ-93	12 ДТ
5	Мицубиши FY515M, Япон	Усан ба хөөсний хөөрөгтэй /8 тн ус ба 1 тн хөөс/	56 ДТ	54 ДТ	12 ДТ
6	Мицубиши FY515P, Япон	Усан хөөрөгтэй автомеханик шат /35 метр/	58 ДТ	54 ДТ	12 ДТ
7	Мицубиши FG535C, Япон	Гэрэлтүүлэг ба цахилгаан үүсгэгч	16 ДТ	4,2 АИ-92	6 ДТ
8	ВОЛВО САКСОН, ШВЕД	Усан хөөрөгтэй ба автохөвөгч	54 ДТ	50 ДТ	12 ДТ
9	ХИНО GD-172S, ЯПОН	Усан хөөрөгтэй /1,5 тн/	29 ДТ	42 ДТ	8 ДТ
10	ИСУЗУ ЕН-700, ЯПОН	Усан хөөрөгтэй /1,5 тн/	29 ДТ	42 ДТ	8 ДТ
11	Мерседес-бенц 608, ГЕРМАН	Гэрэлтүүлэг ба аврах албаны	20 ДТ	36 ДТ	7 ДТ
12	Женерал моторс, АМЕРИК	Усан хөөрөгтэй автомеханик шат /21 метр/	53 ДТ	48 ДТ	12 ДТ
13	Мицубиши L-200, Япон	Мотопомп 0,5 тн	15 ДТ	6 ДТ	2,5 ДТ
14	ЗИЛ-130 АЦ-40 /63 А,Б/, ОХУ	Усан хөөрөгтэй /2,1 тн/	45 А-80	18 А-80	9,6 А-80
15	ЗИЛ-131 АЦ-40, ОХУ	Усан хөөрөгтэй /2,4 тн/	53 А-80	19,2 А-80	10,8 А-80
16	ЗИЛ-131 АЛ-30 /127/, ОХУ	Автомеханик шат /30 метр/	58 А-80	19,2 А-80	10,8 А-80
17	ГАЗ-66 АСО-5, ОХУ	Гэрэлтүүлэг ба цахилгаан үүсгэгч	38 А-80	16,8 А-80	7,8 А-80
18	ГАЗ-66 АЦ-30, ОХУ	Усан хөөрөгтэй /1,5 тн/	38 А-80	16,8 А-80	7,8 А-80
19	ЗИЛ-130 ТСВ-6,	Ус тээвэрлэгч /6тн/	48 А-80	-	9,6 А-80


	ОХУ				
20	УАЗ-469 түүний төрөл, ОХУ	Шуурхай албаны	17 А-80	-	4,2 А-80
21	УАЗ-452 түүний төрөл, ОХУ	Шуурхай албаны	18 А-80	-	4,2 А-80
22	Мицубиши Делика ММС, Япон	Шуурхай албаны	14,6 АИ-92	-	3,2 АИ-92
23	Исузу-FTS 33HL, Япон	Усан хөөрөгтэй /4 тн/	40 ДТ	30 ДТ	4 ДТ
24	Исузу-СYZ51кС, Япон	Усан хөөрөгтэй /8 тн/	45 ДТ	40 ДТ	4,5 ДТ
25	Исузу-СYZ517С, Япон	Усан хөөрөгтэй /10 тн/	45 ДТ	40 ДТ	4,5 ДТ
26	Исузу FVR -30МС, Япон	Автомеханик шат	38 ДТ	40 ДТ	3,8 ДТ
27	Исузу-FTS 33HL, Япон	Гэрэлтүүлэг ба цахилгаан үүсгэгч	40 ДТ	21,6 ДТ	4 ДТ
28	Камаз 61115 АЛ-50	Автомеханик шат	56 ДТ	50 ДТ	5,6 ДТ
29	Камаз, ОХУ	Усан хөөрөгтэй /5 тн/	45 ДТ	22 ДТ	15 ДТ
30	Дайвүү К7С6F, Солонгос	Усан хөөрөгтэй /8 тн/	50 ДТ	35 ДТ	15 ДТ
31	Хово SG210/А2, БНХАУ	Ой, хээрийн түймрийн /21 тн/	80 ДТ	35 ДТ	15 ДТ
32	МАН TFL-4000, Австри	Усан хөөрөгтэй /4 тн/	40 ДТ	18 ДТ	10 ДТ
33	МАН, Австри	Ой, хээрийн түймрийн /2,5 тн/	40 ДТ	18 ДТ	10 ДТ
34	МАН TFL-32, Австри	Автомеханик шат	40 ДТ	22 ДТ	10 ДТ
35	Хово DG32/С1, БНХАУ	Автомеханик шат	50 ДТ	20 ДТ	15 ДТ
36	МАН S/M2-3	Усан ба хөөсний хөөрөгтэй /3,5 тн ус ба 400л хөөс/	40 ДТ	18 ДТ	10 ДТ
37	Вранглер, герман	Шуурхай албаны	20 АИ-95	-	2 АИ-95
38	МАН, Польш	Удирдлагын зориулалттай	40 ДТ	-	10 ДТ
39	АЦ-5,0-40 /МАЗ-5434/, Беларусь	Усан хөөрөгтэй /5тн/	38 ДТ	17 ДТ	10 ДТ
40	АЦ-11-40 /МАЗ-6317/, Беларусь	Усан хөөрөгтэй /11тн/	52 ДТ	24 ДТ	15 ДТ
41	АЛ-32 /МАЗ-5340/, Беларусь	Автомеханик шат	28 ДТ	14 ДТ	9 ДТ
42	АЛ-32 /МАЗ-6302/, Беларусь	Автомеханик шат	32 ДТ	15 ДТ	10 ДТ
43	АПТ-11,0-100 /МАЗ6317/, Беларусь	Хөөсөөр гал түймэр унтраах	52 ДТ	24 ДТ	15 ДТ
44	АНР-133 /МАЗ-6317/ Беларусь	Хөөрөг-хоолойн автомашин	45 ДТ	24 ДТ	15 ДТ
45	ПУМ /МАЗ-6317/ Беларусь	Хөдөлгөөнт удирдлагын байр	52 ДТ	-	15 ДТ

46	АШ /МАЗ-6317/ Беларусь	Удирдлагын автомашин	52 ДТ	-	15 ДТ
47	МАН TFL-3000, Австри	Усан хөөрөгтэй /3,5 тн/	40 ДТ	18 ДТ	10 ДТ
48	Renault АЦ	Усан ба хөөсний хөөрөгтэй /4 тн ус ба 400л хөөс/	45 ДТ	25 ДТ	15 ДТ
48	Дайвүү F4CEF, Солонгос	Усан хөөрөгтэй /6 тн/	50 ДТ	25 ДТ	15 ДТ
49	DAIHATSU Hijet truck Солонгос	Ой хээрийн түймрийн	12 ДТ	-	4 ДТ
50	Донгфенг, БНХАУ	Усан хөөрөгтэй /5тн/	28 ДТ	12 ДТ	8 ДТ
51	PORLAND	Усан хөөрөгтэй /3тн/	16 ДТ	10 ДТ	1,6 ДТ
52	МАН TFL-2000, Австри	Усан хөөрөгтэй /3,5 тн/	40 ДТ	18 ДТ	10 ДТ
53	Киа бонго 3 /4*4/	Ой хээрийн түймэр	15 ДТ	6 ДТ	2,5 ДТ
54	Портер 2 /4*4/	Ой хээрийн түймэр	15 ДТ	6 ДТ	2,5 ДТ
55	Уаз-362223 профи	Ой хээрийн түймэр	19 АИ-92	8 АИ-92	6 АИ-92

Тайлбар: Зам, тээврийн хөгжлийн сайдын жишиг норм батлах тухай тушаал болон энэ тушаалын 1 дүгээр хавсралтад заагдаагүй шинээр нийлүүлэгдсэн гал түймэр унтраах, аврах болон тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжийн шатахуун зарцуулалтын жишиг нормыг нийлүүлэгдсэнээс хойш 3 сарын дотор тогтооно.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2022 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн
4/90 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ, ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИН,
ТЕХНИКИЙН ӨДӨР ТУТМЫН БЭЛТГЭЛ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ
ШАТАХУУН ЗАРЦУУЛАЛТЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

1. Шинээр ашиглалтад авч бэлтгэл, бэлэн байдлын хуваарьт батлан оруулж буй автомашин техникийг ашиглалтын эхний 300 километрын гүйлт буюу тусгай тоног төхөөрөмжийг 8 мото/цаг ажиллуулан зүгшрүүлнэ. Бэлтгэл, бэлэн байдлын хуваарьт тавигдаагүй удаан хугацаагаар (3 сараас дээш) ашиглагдаагүй болон улирлын чанартайгаар хадгалагддаг тусгай зориулалтын автомашин техникийг бэлтгэл, бэлэн байдлын хуваарьт оруулахын өмнөх үеийн техникийн бэлэн байдлыг хангаж автомашины эд ангийн хөдөлгөөнт зүгшрүүлэлтийг 50 километр явж, тусгай тоног төхөөрөмжийг 60 минутаас доошгүй хугацаагаар хийж шалгах.

2. Гал түймэр унтраах, аврах тусгай зориулалтын автомашинд болон тусгай тоног төхөөрөмжинд их засвар хийсний дараа хуваарьт оруулахын өмнө уг автомашиныг 150-аас доошгүй километр явуулж, тусгай тоног төхөөрөмжийг 2-оос доошгүй цаг ажиллуулж зүгшрүүлэлт хийнэ (Дээрхи заалтын үйл ажиллагаанд шаардагдах шатахууны нормыг одоогийн мөрдөж байгаа Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтыг мөрдөх).

3. Өдөр тутмын томилгоот ээлжийн хуваарьт тавигдсан гал түймэр унтраах, аврах зориулалтын автомашин, тоног төхөөрөмжийн шатахууны савны дүүргэлт 80 хувиас доошгүй байна.

4. Гал түймэр унтраах, аврах ажиллагаа, дадлага, сургуулийн үед тусгай тоног төхөөрөмж ажиллуулсан асаалтын нэг цагийг 40 километр, бэлэн байдал хангах зүгшрүүлэлт хийсэн асаалтын нэг цагийг 30 километр шилжүүлэн явсан нийт гүйлт километр дээр нэмж тооцно.

5. Томилгоот ээлжийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах өдөр тутмын зүгшрүүлэлтийн асаалтыг хүйтний улиралд буюу 11 дүгээр сарын 01-нээс дараа оны 04 дүгээр сарын 01-ний хооронд өдөрт 4 удаа буюу асаалт тутамд 15 минутаар, дулааны улиралд буюу 04 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 01-ний хооронд өдөрт 2 удаа буюу асаалт тутамд 15 минутаар хийж гүйцэтгэнэ (Гал түймэр унтраах, аврах зориулалтын автомашины онцлогоос шалтгаалан өдөр тутмын зүгшрүүлэлтийн хугацааг 30 минут хүртэл нэмэгдүүлж болно).

6. Үйлдвэрлэгчээс автомашины цахилгаан хэрэгсэл, зай хураагуурыг цахилгаанаар хангах зориулалттай цахилгааны холболтоор тоноглогдсон автомашинуудыг тавиуланд тохирох хүчдэлд тогтмол холболттой байлгана.

7. Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа болон өдөр тутмын бэлтгэл, бэлэн байдал хангах, тактик, тархалт, өдөр тутмын дасгал сургууль хийх үеийн үйл ажиллагаатай тухайн өдрийн бэлтгэл, бэлэн байдал хангах зүгшрүүлэлтийн асаалтын цагийн хуваарьтай давхцаж байвал асаалтыг хасаж тооцно.